



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 11 дугаар сарын 25 өдөр

Дугаар А-888

Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Игэ.Химийн хорт бодисоос хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах орон тооны бус зөвлөл" ийг байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр.Нийслэлийн нутаг дэвсгэрт химийн хорт бодисын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, ослоос сэргийлэх, түүний хор уршгийг арилгах талаар дүрэмд заагдсан үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг зохицуулах зөвлөлийн дарга Л.Доржсүрэн 1-д үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ



Нийслэлийн нутаг дэвсгэрт химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн:

Дарга

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ЦИХШ-ын дарга, БОК-ын үйлдвэрийн осол, хөнөөх үйлчилгээтэй хорт бодисын алдагдлаас сэргийлэх ажлын хэсгийн дарга

Нарийн бичгийн дарга

-Цэрэг, ирээний хамгаалалтын штабын ирээний хамгаалалтын асуудал хариуцсан ажилтан, ирээний хамгаалалтын ахлах байцаагч

Гишүүдэд:

-Нийслэлийн БОХГ-ын химийн бодис хариуцсан ажилтан, улсын байцаагч

-Нийслэлийн ЭАХСХяналтын албаны хөдөлмөрийн эрүүл ахуйч, Улсын байцаагч

-Стратеги бодлого, төлөвлөлтийн хэлтсийн байгаль орчны бодлогын асуудал хариуцсан ажилтан

-“Тулга” компаний гүйцэтгэх захирал

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх
зөвлөлийн 1998 оны 2-р сар 12-ны тоот
захирамжийн хавсралт

**НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХИМИЙН ХОРТ БОДИС АШИГЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах Зөвлөл цаашид "Зөвлөл" гэнэ. 1 нь химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих, "Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай" конвенцид заасан үүргийг хариуцан хэрэгжүүлэх, болзошгүй ослоос сэргийлэх, химийн хорт бодистой харьцаж ажиллагчдын сургалтыг зохион байгуулж, химийн хорт бодисын улмаас үүдэн гарсан хохирол, хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохицуулахад зөвлөх үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

2. Зөвлөл нь Нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллана.

3. Зөвлөлийн дарга нь Нийслэлийн Засаг дарга байна.

4. Зөвлөл нь нутаг дэвсгэрийн шинж чанартай ажиллах бөгөөд түүний бүрэлдэхүүнд холбогдох газар, аж ахуйн нэгж, байгууллагын зохих албан тушаалтан орсон байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох газар, аж ахуйн нэгж, байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зөвлөлийн дарга томилно. Зөвлөл нь нийслэлд 5-7 хүн, холбогдох дүүрэг, аж ахуйн нэгж байгууллагад 3-5 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус салбар зөвлөлтэй байна. Тэдгээр нь тухайн нийслэл, дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага дахь химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, ослоос сэргийлэх түүний хор уршгийг арилгах үүрэгтэй байна. Орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн нийслэл, дүүргийн Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчийн шийдвэрээр томилно.

5. Зөвлөл нь химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль тогтоомж, олон улсын худалдаанд химийн хорт бодисын талаар мэдээлэл солилцох Лондонгийн зарчим, "Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах" конвенци, холбогдох бусад гэрээ хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

6. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, зохих журмын дагуу хийгдсэн тэмдэгтэй байна.

Хоёр. Зөвлөлийн үүрэг эрх

7. Зөвлөл нь дараахь үүрэгтэй байна.

а) Химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа, химийн хорт бодисын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж холбогдох асуудлаар зөвлөмж гаргах.

б) Химийн хорт бодисыг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, хэрэглэх, устгах үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон дүрэм, журам, зааврын төслийг боловсруулах, хэлэлцэх санал, дүгнэлт гаргах.

в) Улсын хэмжээнд хэрэглэж байгаа химийн хорт бодисын ашиглалт, зарцуулалтын тайлан гаргаж улсын бүртгэл хөтлөн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

г) Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад онцгой хортой химийн бодис үйлдвэрлэх, импортлох худалдах, хэрэглэх устгах зөвшөөрөл олгох асуудлаар дүгнэлт гаргах.

д) Урсамал хамгаалал, бордоо болон туршилтын зориулалтаар ашиглах агрохимийн бодисын жагсаалт, тэдгээрийн хэмжээг шинэчлэн тогтоох саналыг хэлэлцэж дүгнэлт гаргах.

е) Химийн хорт бодисын улмаас үндэсний аюулгүй байдал болон хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол, аюул учирвал түүнийг арилгах талаар санал боловсруулах.

ж) Химийн хорт бодистой харьцаж ажиллагсадын мэдлэг, дадлагыг дээшлүүлэх, ирээдийг химийн бодисоос хамгаалах асуудлаар төрөл бүрийн сургалт, сурталчилгаа байгуулах.

з) Химийн хорт бодисын талаар олон улсын байгууллагатай мэдээлэл солилцох, ирээдийг мэдээллээр хангах арга хэмжээг аэч хэрэгжүүлэх.

и) Монгол улс нэгдэн орсон химийн хорт бодисын болон химийн зөөсгийн талаархи олон улсын гэрээ хэлэлцээрээр манай талын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, энэ талаар холбогдох санал, зөвлөмж боловсруулах.

к) Химийн хорт бодисын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, химийн хорт бодисын осол гамшгийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирсан хор уршиг, хохирлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах.

л) Ажил төрлийн шугамаар хүлээн авсан мэдээ, материалыг зохих журмын дагуу нууцлан хадгалах.

8. Зөвлөл нь дараах эрхтэй байна.

а) Химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах асуудлаар арвачлал, зөвлөмж гаргах, нийслэл, дүүрэг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид ажиллах орон тооны бүс

зөвлөлийн дүрмийг хууль тогтоомжийн акт, энэхүү дүрэмд нийцүүлэн баталж мөрдүүлэх,

б)Энэ дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар ирэн, аж ахуйн нэгж байгууллагаас шаардлагатай мэдээ, тайлан, судалгааг гаргуулан авах

в)Химийн хорт бодис ашиглаж байгаа байдалд шалгалт, тооллого, ажлын зурвг авалт хийх, шинжилгээнд сорьц авах ажлаар Зөвлөлийн гишүүд аж ахуйн нэгж, үйлдвэр, байгууллагад чөлөөтэй нэвтрэн орох,

г)Шаардлагатай тохиолдолд энэ дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ тухайн аж ахуйн нэгж байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр холбогдох байгууллагуудын лаборатори, ажилтан, эрэгмтдийг татан оролцуулах,